

Дамчаабадгарын Содномжамц<sup>1</sup>✉, Батмөнхийн Цогтбаатар<sup>2</sup>, Норовцэдэнгийн Амгалан<sup>3</sup>,  
Лхагвадоржийн Мөнхбаяр<sup>2</sup>, Ганболдын Анхсанаа<sup>4</sup>,  
Ням-Осорын Нандин-Эрдэнэ<sup>1</sup>, Мөнхцогтын Ууганбаяр<sup>3</sup>

<sup>1</sup>Жилиний их сургууль, Археологийн сургууль, 130012, Чанчунь, БНХАУ

<sup>2</sup>Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,  
Монгол улс, Улаанбаатар -13330, Энхтайвны өргөн чөлөө,  
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн 1 байр

<sup>3</sup>Монголын Бурхан Шашинтны Төв-Гандантэгчэнлин хийд,  
Эрдэм соёлын хүрээлэн, Улаанбаатар, Монгол

<sup>4</sup>Соёлын өвийн үндэсний төв,  
Монгол улс, Улаанбаатар-17120,  
Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 2

### Ингэт толгойн хөшөөний дүрслэл ба он цагийн асуудал

**Хураангуй.** Монгол нутагт бурхны шашин хэдий үед анх дэлгэрсэн тухай түүхийн асуудлыг эрдэмтэн судлаачид сурвалж бичгийн мэдээнд тулгуурлан сонирхон судалж ирсэн боловч түүнийг батлах археологийн хэрэглэгдэхүүн одоо хүртэл хангалттай бус байна. Харин түрүү үеийн дэлгэрэлтийн түүхийн асуудлыг цаашид нэхэн тодруулахад Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт орших Ингэт толгойн хүн чулуун хөшөө чухал хэрэглэгдэхүүн болох бөгөөд биеийн ерөнхий төрх, үсний засал, нүүр царай, хоёр гарын байрлал, хувцас зэргээрээ бурхан багшийн дүр төрхтэй ижил байна. Дүрслэлийн эдгээр шинж нь цаанаа нарийн утга бэлгэдэлтэй ба хөшөөний тэргүүнд үснирийг (ushnisha) овгор байдлаар товойлгон урласан бол баруун гар нь дээдийг өгөхийн мутарлаг (abhaya mudra), зүүн гар нь авралыг өгөхийн мутарлаг (varaba mudra) бөгөөд бурхны номт дээл (kesa) өмссөн байдлаар дүрслэн харуулсан нь хамаг бүхнийг энэрч хамгаалах чанад агуулгатай аж. Үүнтэй ижил төстэй бурхан дүрслсэн хөшөө Дундад Азийн Гандхара, Умардын төрийн үеийн сүм хийдийн тууриас олон тоогоор олдсоны зэрэгцээ одоогоор бүс нутгийн хэмжээнд хамгийн ойролцоо баримт нь Буриадын нутаг дахь Иволжийн дурсгалаас олдсон 441 онд холбогдох гурван майдар бодсидавагийн дүрт хүрэл баримал тооцогдоно. Ингэт толгойн хөшөөг янз бүрийн шалтгаанаар хэд хэдэн удаа зөөсөн болохыг археологи болон угсаатны зүйн мэдээ баримт нотлох бөгөөд бидний таамаглаж буйгаар анх Ингэт толгойн орой дээрх тахилын сүмийн үүдэнд оршиж байсан хэмээн үзэв. Харьцуулсан болон лабораторийн судалгааны үр дүнд тулгуурлан Ингэт толгойн бурхны дүрт хөшөөний он цагийг НТ V-VI зууны үе буюу Жужаны хаант улсын төгсгөл үед холбогдуулан үзэж байна.

**Түлхүүр үг:** Ингэт толгой, Бурхны шашин, Жужаны хаант улс, Хөшөө чулуу, мутарлаг

Sodnomjamts Damchaabadgar<sup>1</sup>✉, Tsogtbaatar Batmunkh<sup>2</sup>,  
Amgalan Norovtseden<sup>3</sup>, Munkhbayer Lkhagvadorj<sup>2</sup>,  
Ankhsanaa Ganbold<sup>4</sup>, Nandin-Erdene Nyam-Osor<sup>2</sup>,  
Uuganbayar Munkhtsogt<sup>3</sup>

<sup>1</sup>School of Archaeology, Jilin University, Changchun 130012, China

<sup>2</sup>Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences Building-1,  
Peace avenue, Ulaanbaatar, Mongolia

<sup>3</sup>Institute of Education and Culture,  
Mongolian Buddhists centre Gandantegchenlin Monastery,  
16 khoroo, Bayangol District, Ulaanbaatar, Mongolia

<sup>4</sup>National Center for Cultural Heritage,  
Buyant-Ukhua 2, Ulaanbaatar 17120, Mongolia

### Iconography and Chronology of the Inget Tolgoi Statue

**Abstract.** The historical timeline of Buddhism introduction to Mongolia has long been studied through literary sources. However, archaeological evidence to substantiate these records remains insufficient. The anthropomorphic stone statue

at Inget Tolgoi, located in Selenge Soum of Bulgan Province, is a crucial artifact for clarify the history of early Buddhist dissemination. Its general physical form, hairstyle, facial features, hand gestures (mudras), and the attire is resembled to the traditional iconography of the Buddha. These iconographic attributes carry profound symbolic meanings. The protrusion on the head represents the ushnisha. The right hand is depicted in the abhaya mudra, representing giving. Meanwhile the left hand shows the varada mudra, signfying the granting of boons. The figure is also draped in a kesa (a robe worn by monk), deeply featureing the universal compassion and protection. Similar Buddhist sculptures have been extensively recovered from Gandhara in Central Asia and temple ruins from the Northern Dynasties of China. Regionally, the most closely related artifact is a bronze triad of the Maitreya Bodhisattva dating to 441 CE, discovered at the Ivolga settlement in Buryatia. Archaeological and ethnographic data indicate that the Inget Tolgoi statue was relocated several times for various reasons. However, we hypothesize that it was originally enshrined temple atop Inget Tolgoi hill. Based on comparative analysis and laboratory findings, this Buddhist-style statue is dated to the 5th–6th centuries CE. This period corresponds to the late of the Rouran Khaganate.


**Keywords:** *Inget Tolgoi, Buddhism, Rouran Khaganate, Stone statue, Mudra*

### Удиртгал

Булган аймгийн Сэлэнгэ сумын нутаг Ингэт толгойн өвөрт өвөрмөц дүрслэлтэй нэгэн хүн чулуун хөшөө байдаг. Уг хөшөөг нутгийн ардууд “Далхавандад” хэмээн нэрлэж эртнээс нааш дээдлэн шүтсээр иржээ. Харин эрдэм шинжилгээний хүрээнд “Ингэт толгойн хүн чулуу” гэж хэвшсэн ба Хятан улсын үед хамаарах бомбын шашны хувраг хүнийг дүрсэлсэн гэж үздэг. ШУА-ийн Археологийн хүрээлэн Гандантэгчэнлэн хийдийн Эрдэм соёлын хүрээлэнтэй хамтран Голомт банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Өв Соёлын Голомт” төслийн хүрээнд 2023 оноос эхлэн Ингэт толгойн хөшөө чулууны дүрслэл, утга бэлгэдэл, он цагийг тодруулах үүднээс толгойн орой дээрх чулуун өрлөг бүхий байгууламжийн дэвсгэр зургийг үйлдэж, малтлага судалгааны ажлыг эхлүүлсний зэрэгцээ Соёлын өвийн үндэсний төвтэй хамтарч хүн чулуун хөшөөний бохирдол, гэмтлийг тодорхойлон нарийвчилсан хэмжилт судалгааг хийх, сэргээн засварлах, хэв хуулбар авах зэрэг ажлыг үе шаттайгаар гүйцэтгэж ирсэн (Зураг 1). Ингэт толгойн хүн хөшөөг анх

1978 онд аймгийн, 2008 онд улсын хамгаалалтад байх дурсгалын жагсаалтад оруулсан бол Монгол улсын Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор “Улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал”-ын шинэчилсэн жагсаалтад тус тус бүртгэсэн байдаг.

Судалгааны тойм ба хөшөөг зөөсөн түүх. Одоогоор бидэнд мэдэгдэж буйгаар Ингэт толгойн дурсгалын тухай анх 1953 онд эрдэмтэн О.Намнандорж үзэж товч тодорхойлолт үйлджээ. Тэрээр орон нутгийг судлах, музейн үзмэр цуглуулах зорилгоор Төв, Булган, Архангай, Хөвсгөл аймгийн нутгаар 1953 оны 9-р сарын 15-наас 11-р сарын 06 хүртэл нийт 53 хоног 3832 км зам туулсан тухай аян замын товч тэмдэглэлийг 1956 оны “Шинжлэх ухаан” сэтгүүлийн №3-д хэвлүүлжээ. Уг тэмдэглэлд дурдсанаар Ингэт толгой орчмоос арслан зааны яс илэрсэн ба сангийн аж ахуйн байшингийн орчимд байдаг тухай аман мэдээг шалгах зорилгоор Сэлэнгэ сумыг зорьж очсон боловч тэдгээр яснууд аль хэдийн үрэгдэж алга болсон байжээ. Улмаар Өмнөд Ингэт толгой дээр гарахад палеолитын дээд шатанд хамаарах



Зураг 1. Булган аймгийн Сэлэнгэ сумын Ингэт толгойн дурсгалт газрын байршлын зураг

чулуун зэвсгийн зүйлс олон тоогоор олдсоны зэрэгцээ 30 х 30 метр хэмжээтэй дөрвөлжин хэлбэрийн балгасны буйр буйг анзаарч дээврийн ваар, тоосгоны хагархай хэсгээс дээж авчээ. Мөн Ингэт толгойн өвөрт орших “Далхавандад” нэртэй чулуун хүн хөшөөнд хоцрогдсон хүмүүс одоо ч гэсэн мөргөдөг хэмээн онцлон бичсэн байдаг. Тэрээр толгойн орой дээрх туурь болон хүн хөшөөд нь эртний бөөгийн мөргөлийн төв орон байсан тухай тэмдэглээд Сэлэнгэ мөрний арал дээр орших Хойд Ингэт толгой дээр мөн адил барилгын туурь байдаг тухай сонссон хэмээжээ. Мөн Ингэт толгойн баруун ёроолд дээрээ чулуун дараасгүй булш байсан нь эргийн нурангиар ил гарч хүний ясны тал хэсэг, 2 ширхэг шавар ваар гарсан нь хүннүгийн үеийн булш бололтой (Намнандорж 1956, 70) зэрэг олон чухал мэдээллийг нийтлүүлжээ.

Тухайн цаг үеэс хойш Ингэт толгойн дурсгалын тухай мэдээлэл судлаачдын сонорт хүрч цаашид нарийвчилсан судалгаа хийх үндэс суурь нь тавигджээ. Эл хөшөөг 1964 онд Н. Сэр-Оджав, Д. Дорж, С. Михайлов нарын судлаачид Сэлэнгийн шинжилгээний ангийн хүрээнд үзэж *“Ингэт толгойн сангийн аж ахуйн төвд байгаа хүн чулуу 1.94 м өндөр, 0.80 м өргөн, зогсож байгаа хүний дүрс гаргасан элсэрхэг улаан шаргал чулуу байна. Эртний түргийн (Түрэг) булшин дээр босгодог хүн чулуунаас маш өөр, газар хүртэл унжсан өргөн ханцуйтай дээлтэй, гарыг эвдсэн учир чухам юу барьж, ямар байдалтай байсан нь сайн мэдэгдэхгүй байна...”* хэмээн тэмдэглэж, он цагийн сайтар харьцуулан нягтлан гаргах шаардлагатай болохыг дурдсан байдаг. Уг хөшөө анх Ингэт толгойн өвөрт зоолттой байсан боловч 10-аад жилийн өмнө хуга татан буулгасныг Б.Ринчен академичийн зөвлөснөөр сангийн аж ахуйн багш нар сургуулийнхаа хашаанд авчирч босгожээ (Сэр-Оджав 1965, 62).

Уг хөшөөг 1953 оны намар Ингэт толгойн өвөрт байхад нутгийн иргэд ихээр шүтэж мөргөдөг байсан талаар дээр дурдсан билээ. Тэгвэл Сэлэнгэ сумын иргэн Ц.Баатарын бидэнд өгсөн мэдээллээр шашин шүтэх хориотой байсан цагт хүмүүс нууцаар мөргөж, зоосон мөнгө ихээр өргөдөг байсан тул 1954 онд сургуулийн хүүхдүүдээр ухуулж гаргаад, трактороор чирэн олны хөлөөс зайлуулан Ингэт толгойн баруун талд Сэлэнгэ мөрний тохойд аваачиж орхисон аж. Улмаар тэндээс дахин зөөгдөж сургуулийн хашаанд аваачин босгосон байх үед буюу 1964 онд С.Сэр-Оджав нарын судлаачид үзэж тодорхойлсон байна. Харин 1968 онд Ю.Цэдэнбал тэргүүтэй нам, засгийн төлөөлөгчид Ингэт толгойн сангийн аж ахуйн ажил байдалтай танилцаж, сургуулийн өмнө авхуулсан гэрэл зурагт (Мөнхнаран 2023,

67) хөшөө чулууны зүүн хэсэг нь орсон ба нүүрийг баруун хойд зүгт хандуулан босгосон байжээ (Зураг 2). Сургуулийн хашаанд байх үед мөн л хүмүүс нууцаар мөргөж, хүүхдүүд сайн дүн авахыг гуйх зэрэг үйлдэл гаргаж байсан тул 1973 оны орчимд Б.Батмөнх, Л.Жамаа нарын багш нар оролцож Д.Болд гэдэг жолооч трактороор чирч Ингэт толгойн өврийн одоогийн байгаа газарт авчирсан түүхтэй аж<sup>1</sup>.



Зураг 2. Ингэт толгойн хөшөө 1968 онд сургуулийн хашаанд байх үеийн зураг

1990 онд Д.Баяр, Х.Лхагвасүрэн нарын судлаачдыг очиж үзэхэд Ингэт толгойн баруун урд үзүүрт хүн чулууг нүүрээр нь урагш харуулан зоосон байжээ. Судлаачид хөшөөний ерөнхий дүр төрхийг сайтар тодорхойлон бичсэн нь одоо судалгааны чухал эх сурвалж болно. Учир нь 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш шашин шүтэх эрх чөлөөтэй болсноор хүмүүс хөшөөнд улам ихээр сүсэглэн мөргөж биед нь шар тос түрхэх, сүү өргөх явдал эрс нэмэгдсэн тул зарим дүрслэлүүд бүдгэрч одоо мэдэгдэхгүй болоход хүргэжээ. Харин Д.Баяр гуайн тайланд дурдсанаар дээл хувцасны энгэр талд хэвлийгээс доош хэсэгт улбар өнгийн зос будгаар ханан хээ мэт дүрс гарган дүрсэлсэн нь тодорхой мэдэгдэж байсныг гар зурагт харуулжээ (Зураг 3). Түүнчлэн хөшөө чулууны өмнө талын овоолго чулуун дунд орчин үеийн янз бүрийн төмөрлөг зүйлс байгаагийн дотор монголын дорнод хэсгийн хүн чулуунд дүрсэлдэг мөнгөн цомтой ижил хийцтэй ширмэн цөгц байсныг онцлон тэмдэглэжээ (Баяр 1990, 5-7).

2023 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид “Өв соёлын голомт”

<sup>1</sup> Дээрх мэдээг Булган аймгийн Сэлэнгэ сумын Ингэт толгойн сургуульд ажиллаж байсан, одоо мөн тэнд амьдарч байгаа Ц.Баатар, Л.Болдбаатар, Б.Батмөнх нарын зэрэг хүмүүсээс авав.



төслийн хүрээнд Ингэт толгойн хөшөө чулууны он цаг, хэлбэр хийц, дүрслэлийн утга бэлгэдлийг нягтлах, бохирдол гэмтлийн хэмжээг тодорхойлж сэргээн засварлах үүднээс хөшөө чулууны гурван хэмжээст нарийн зураглал хийж, хэв хуулга авч бүрэн баримтжуулсны зэрэгцээ Ингэт толгойн орой дээр орших байгууламжийн төв хэсэгт сорилтын малтлагыг анх хийсэн юм. Мөн түүнчлэн Ингэт толгой орчимд хайгуул хийж толгойн урд өврийн хадны зураг, бурхны хөрөг, баруун хойд талд байх төвөд бичээс, суваргын зураг зэргийг бүртгэн баримтжуулсан. Ингэт толгойн дурсгал нь хуучин чулуун зэвсгийн дээд шатнаас XX зууны эхэн үе хүртэлх түүхийн олон үеийн дурсгалыг өөртөө агуулсан чухал газар болох нь мэдэгдэж байна. Түүнчлэн өнөөг хүртэл Киданы үеийн хүн чулуу хэмээн бүртгэгдэж ирсэн дурсгал нь бурхан багшийн дүр бүхий хөшөө болохыг тодруулж, уг чулуун хөшөө нь Ингэт толгойн орой дээрх байгууламжтай холбоотой (Цогтбаатар нар 2023) хэмээн үзсэн юм. Бурхан багшийн дүр төрхийг хамгийн анх бүтээсэн Зандан зуу бурхнаас үлгэр авч Ази даяар зандан модоор, чулуугаар сийлэн бүтээх уламжлал дэлгэрсэн бөгөөд одоо Буриадад хадгалагдаж буй Зандан зуу бурхны лагшин дүртэй Ингэт толгойн хүн чулуу үндсэн бүх шинжээрээ адил хэмээн үзжээ (Амгалан 2024, 50-51). Иймэрхүү санал дүгнэлтийг сүүлийн үед уг хөшөөг анх удаа үзэж танилцсан гадаад, дотоодын зарим судлаачид илэрхийлж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Ингэт хэмээх нэрийн тухайд. Нутгийн иргэд эрт цагт энэ нутагт ганц ингэтэй хүн амьдарч байсан тухай домгийг Ингэт толгойтой холбон


ярьдаг. Мөн эртний сурвалж бичигт монголын хаадыг оршуулаад тэр газрыг хожим олж тахил тайлга үйлдэх зорилгоор ботго алж булаад, ингэ нь тэр газрыг олж буйлдаг гэсэн домгийн талаар тэмдэглэжээ (Баяр 1990, 8). Харин түүхч Ц.Хандсүрэн гуай сурвалж бичгээс Жужаны хаант улсын түүхэнд хамаарах хааны угсааны хүний нэрийг Ингэт хэмээн буулгаж уншсан нь ихээхэн сонирхол татаж байна. Тухайлбал Жужан улсын хоёр дахь хаан Чулугухайн дөрөв дэх үеийн дөч болох хүн “蕴圪提-yungeti” хэмээх нэртэй байсан нь “Ингэт” гэсэн монгол үг бололтой (Хандсүрэн 2005, 9). Харин Г.Сүхбаатар гуай Вэньгэти гэдэг үгийг тэр үеийн дуудлагаар онгудай гэж байсан хэмээн дурдсан байдгийг бас анхаарах нь зүйтэй (Сүхбаатар 1992, 211). Энэ тухай Вэй улсын судрын Жужаны бүлэгт тодорхой тэмдэглэжээ.

《魏书》卷一百三《蠕蠕》

“车鹿会死，子吐奴愧立。吐奴愧死，子跋提立。跋提死，子地栗哀立。地栗哀死，其部分为二，地栗哀长子匹候跋继父居东边，次子缁纥提别居西边。及昭成崩，缁纥提附卫辰而贰于我”。

《Вэй улсын судар》103-р бүлэг《Жужан》:

“Чулухуйг нас барахад хүү Тунүгүй нь залгамжлав. Тунүгүйг нас барахад хүү Бади нь залгамжлав. Бадиг нас барахад хүү Дисуань нь залгамжлав. Дисуанийг нас барсны дараа түүний аймаг хоёр хэсэг хуваагдав. Дисуаний ахмад хүү Пихоуба эцгийгээ залгамжлан зүүн талд сууж, удаах хүү Юньгэти (缁纥提) нь тусгаарлан баруун талд суув. Жаочэн (хаан) тэнгэрт хальсны дараа, Юньгэти нь Вэйчэнтэй хавсаж, манай (Вэй) улсад хоёр нүүр гаргах болов. (魏书 2000, 1549).



Зураг 3. Ингэт толгойн хөшөөний гэрэл зураг болон гар зураг (Баяр 1990)

Вэй улсын сударт тэмдэглэгдсэн дээрх мэдээнээс үзэхэд Юньгэти буюу “Ингэт” хэмээх хүн нь хааны угсааны хүн болох нь төвөггүй мэдэгдэх ба уг сурвалжид НТ IV зууны сүүлийн хагас орчимд болсон үйл явдлыг тэмдэглэжээ. Хэдийгээр уг Юньгэти хэмээх хүн нь бидний судлан буй Ингэт толгойн дурсгалтай шууд хамааралгүй боловч нэрийн хувьд анхааралгүй өнгөрч боломгүй билээ. Мөн Бэйши буюу Умардын түүх сурвалжид “*缁纓提-yungeti*” гэж ижил ханз үсгээр галиглаж тэмдэглэсэн байна (北史 2000, 2157). Ямартай ч Ингэт хэмээх нэр нь Жужаны хаант улсын үеийн монгол үг болох тухай ахмад түүхчийн тодруулга нь өнөөгийн Ингэт толгой хэмээх нэртэй газрын орчин тойронд бидний сүүлийн жилүүдэд хийж буй археологийн судалгааны үр дүнд илрүүлсэн олдвор, дурсгалт газрын он цагийн хамаарлыг тогтооход холбогдож байгаа нь сонирхолтой юм. Энэ бүс нутгийн газар усны нэрийг шүүн үзэхэд Ингэт гэсэн нэртэй хэд хэдэн газар байна. Тухайлбал Ингэт толгойн хойд талд Сэлэнгэ мөрний салаа дунд арал дээр орших өөр нэг толгойг Хойд Ингэт хэмээн нэрлэхээс гадна Бүхэнгийн нурууг урд талаас давах давааг Ингэтийн даваа, түүний араас эх авч Сэлэнгэ мөрөнд цутгах голыг Ингэтийн гол хэмээн нэрлэдэг.

**Ингэт толгойн хөшөөний дүрслэл.** Ингэт толгойн хөшөөний дүрслэлийг хамгийн анх сайтар тодорхойлсон судлаач бол доктор Д.Баяр юм. Түүний тайланд дурдсанаар хөшөөний “*толгойг нягт барьсан дүгрэг малгай өмссөн нь орой дээрээ овгортой. Энэ нь үсээ толгойн орой дээр бөөрөнхийлөн овоолж хэлбэрт нь тохирсон малгай өмссөнийг харуулж байна. Өргөн дугариг царайтай, том нүдтэй, нүдний дотуур давхар зураасаар хөвөөлж дунд нь цөцгий гаргасан нь баруун талын нүдэнд нэлээн тодорхой мэдэгдэнэ*” хэмээн онцгой шинжүүдийг гярхай ажиглан бичжээ. Мөн баруун, зүүн гарыг тохой хэсгээр нь нугалж урагш харуулан сав барьсан байсан болов уу хэмээн таамагласан ба сарвуу хэсэг хугарсан тул тодорхой мэдэгдэхгүй гэжээ (Баяр 1990, 6). Хугарлын байдлыг нягтлан үзэхэд хоёр гарыг цээжний өмнө холбож барьсан шинж мэдэгдэхгүй ба толгойн орой дээрх нь малгай гэхээсээ илүүтэй үсийг овгор байдлаар зассан шинжтэй байна.

Бид Ингэт толгойн хөшөөг орчин үеийн багаж төхөөрөмжашигланнарийвчилсанбаримтжуулалт, хэмжилт судалгаа хийсний үр дүнд холбогдох он цаг, утга бэлгэдлийн талаар дараах таамаглалыг дэвшүүлэв. Энэхүү хүн хөшөөний хийц хэлбэрийг дэлхийн бусад газраас олдсон дурсгалуудтай олон талаар жишиж харьцуулан шинжилж үзэхэд бурхны дүрийг босоо байдлаар урласан болох нь тодорхой мэдэгдэж байна. Ер нь аливаа бурхны

дүрийг хөшөө болгон бүтээж ирсэн тиг уламжлал, утга бэлгэдэлд тулгуурлан түүнийг таньж тогтоох олон төрлийн арга бий. Ихэвчлэн биеийн ерөнхий төрх, тэргүүн, нүүрний хэлбэр, мутарлаг буюу гарын байрлал, дээл хувцас зэрэг шинжээр нь ялган тогтоодог. Эдгээрийн дотроос гарын байрлал хамгаас чухал бөгөөд тухайн бурхны мөн чанар, дүрийг таних гол шинж болох тул зөвхөн буддын шашин гэлтгүй христийн шашинд ч гэсэн ялгаатай гарын байрлал бүр нь цаанаа утга бэлгэдэлтэй байдаг.


Ингэт толгойн хөшөөний тэргүүнд үснирийг (*ushnisha*) овгор байдлаар товойлгон урласан бол баруун гарыг тохой хэсгээр нь нугалж алгыг урагш харуулсан нь дээдийг өгөхийн мутарлаг (*abhaya mudra*) хэмээн нэрлэдэг. Хэдийгээр гарын сарвуу хугарч мэдэгдэхгүй болсон хэдий ч хугарлын ул мөрөөс харахад дунд хурууны үзүүр хэсгийн ерөнхий хэлбэр дээд хэсэгт мэдэгдэнэ. Зүүн гарыг бугуй хэсгээр нь нугалж алгыг урагш харуулсан нь авралыг өгөхийн мутарлаг (*varaba mudra*) бүхий бэлгэдэлтэй ба урт өргөн хормойтой бурхны номт дээл (*kesa*) өмссөнөөр дүрслэн харуулжээ. Хөшөөний одоо мэдэгдэж буй өндөр 220 см бол газарт ухаж суулгасан хэсэг нь 70 см урт ба нийт өндөр 290 см, цээжний өргөн 78 см, зузаан 25-32 см хэмжээтэй (Зураг 4, 5). Улаан хүрэн өнгийн боржин чулуугаар урласан нь хөшөөний ар талын тос түрхээгүй хэсэгт тодорхой мэдэгдэх ба үүнтэй ижил бүтэцтэй чулуулаг Ингэт толгой болон Хойд Ингэт толгойн хадан гарцуудад бий. Тиймээс хөшөөний чулууг ойролцоох газраас олборлон авч засаж янзлан урласан хэмээн үзэж болно.

Хөшөөний баруун, зүүн гарын сарвуу хэсэг, хоёр чих, хамар, амны хэсэг хугарч унасан байдалтай ба чухам хэдий үед ингэж гэмтсэн нь тодорхойгүй. 1954 оноос хойш 3 удаа зөөхдөө эсгийнд боож трактораар чирч явсан хэмээн нутгийн иргэд хуучилдаг. Ямартай ч хөшөөг мухар сүсгээр тахин шүтэж буй гэх шалтгаанаар хүчээр буулгаж зөөх үед хүмүүс ихэд хүндэтгэлтэй хандаж байсан нь илэрхий тул ямар нэг байдлаар хамгаалалт хийсэн байж таарна. Зарим хүмүүсийн хэлж буйгаар 1938 онд Моностойн аманд мод бэлтгэж байсан хоригдлууд хамрыг нь хуга цохисон гэсэн ам дамжсан яриа бий. 1990 онд авсан гэрэл зураг, тайлангуудад энэ талаар тодорхой дүрслэн өгүүлжээ. Тухайлбал дух, хоёр чихийг цемент мэт зуурмаг оролцуулан шавж янзалсан нь анхнаасаа ийм аргаар урласан эсвэл нэмж засварласан эсэх нь тодорхойгүй гэжээ (Баяр 1990, 6). Харин хөшөөг Ингэт толгойн өвөрт авчирсны дараа сургуулийн монгол хэл, уран зохиолын багш н.Цэцрэн гэдэг хүн чих, духны хэсгүүдийг цемент зуурч нааж сэргээсэн талаарх нутгийн иргэдийн өгсөн мэдээ үнэн бөгөөд





Зураг 4. Ингэт толгойн хөшөөний гурван хэмжээст зураглал (Соёлын өвийн үндэсний төв 2023);  
а. Нүүрэн тал b. Зүүн тал, c. Ар тал, d. Баруун тал, e. Баруун урд тал




Зураг 5. Ингэт толгойн хөшөөний гар зураг

тухайн хэсгүүдэд зуурмагийн ширхгүүд тодорхой харагддаг.

Мутарлаг буюу гарын байрлалын хувьд баруун гарыг тохойгоор нугалж алгыг урагш харуулах абая мутарлаг нь сүнслэг төрлийн хор хөнөөлөөс бие махбодыг хамгаалж аврах, сэтгэл санааг тайвшруулах бэлгэдэлтэй бол зүүн гарыг тохойгоор нугалж алгыг урагш харуулах варада мутарлаг нь хүслийг хангаж авралыг өгөх бэлгэдэлтэй (Fridrick W.Bunce 2009, 2; 267). Буддын шашны бурхдад абая болон варада мутрыг хослуулан хэрэглэснийг *seган-semui-in* (*mudra*) хэмээн нэрлэх ба ихэнхдээ босоо дүртэй

бурхдын баруун гар нь цээжний түвшинд, зүүн гар нь бүсэлхийн орчимд байрладаг. Энэ нь бурхан багш сүсэгтэн олныг айдсаас ангижруулж, хүсэл ерөөлийг соёрхож буйн илрэл хэмээн бэлгэддэг (Fridrick W.Bunce 2009, 209) аж.

Ингэт толгойн бурхан багшийн дүр бүхий хөшөөний гарал үүсэл болон хэв маягийг нарийвчлан тогтоохын тулд бусад газраас олдсон хөшөө чулуутай харьцуулан үзэх зайлшгүй шаардлагатай. Үүнтэй ижил төрлийн хөшөө монгол нутгаас илрээгүй боловч Энэтхэг, Пакистан, Афганистан болон БНХАУ-ын торгоны зам дагуух бүс нутгаас олон тоогоор илэрч олджээ.



Зураг 6. Булган аймгийн Бугат сумын Цацын хотгорын хүн чулуун хөшөөний гар зураг.

Хөшөө чулуугаар бурхан бүтээх тиг уламжлал эртний Энэтхэгийн Гандхара (Gandhara) болон Матхура (Mathura) бүс нутгаас эхлэлтэй бөгөөд дүрслэлийн хэв маягийн хувьд түүхэн аль үед хамаарч буйгаасаа шалтгаалан өөрийн гэсэн онцлог төрх бүхий хэв шинжтэй байдаг. Кушан (НТ 30-375) улсын үед Гандхара болон Матхура хэв маяг, Гупта (НТ 320-550) улсын үед Матхура болон Сарнат хэв маяг үүсэн бий болж Азийн олон улс оронд өргөн дэлгэрчээ. Харин түрүү үеийн Гандхара хийцийн бурхад нь өрнө зүгийн европиод хүний дүр төрх бүхий онцлогтой байдаг нь Грек, Ромын сонгодог урлагийн нөлөө хэмээн үздэг (Peter Stewart 2024, 2).

Ингэт толгойн хөшөөтэй адил төстэй дүрслэл бүхий дурсгал одоогийн байдлаар Монгол нутгаас илрээгүй байна. Харин Ингэт толгойн дурсгалаас баруун тийш 30 гаруй км зайд Эг-Сэлэнгийн бэлчрээс доош Булган аймгийн Бугат сумын нутаг Цацын хотгор хэмээх газарт нэгэн өвөрмөц дүрслэлтэй хөшөө чулуу бий. Уг хөшөө нь бурхны дүрт хөшөөнөөс хэмжээний хувьд харьцангуй жижиг, дүрслэлийн хувьд нэлээд ялгаатай боловч хоёр гарын алгыг цээжнийхээ өмнө залбиран барьсан буйгаараа бурхны шашны зарим бэлгэдлийг агуулсан мэт санагдана. Толгойн хэсэгт үсний заслыг тодорхой гаргаагүй ба хоёр чих, бүлтгэр нүд, хамар, шүд, урт сахал, богино хүзүүтэй. Цээжин хэсэгт хоёр гарын алгаа урдаа хавсран залбирсан мутартай. Мөн хоёр хөхний товч, гэдсэнд хүйсний нүхийг тодорхой харуулсан ба хажуу талд ээтэн хоншоортой гутал өмссөн хөлийг нарийн зураасаар тодорхой дүрсэлжээ. Толгойн орой хэсэг хонхор ба энэ нь хугарсан эсвэл анхнаасаа ийм байсан эсэх нь сайн мэдэгдэхгүй.

Уг хар хөх өнгийн боржин чулуун хөшөө нь 175 см өндөр, 30 см өргөн, 40 см зузаан хэмжээтэй. Одоо тэр хавийн нутгийн иргэд “газар тариалангийн бурхан” хэмээн дээдлэн, гадуур нь хашаа барьсан ба ойр орчимд нь ямар нэг байгууламжийн ул мөр байхгүй, мөн хөшөөг газарт суулгаж зоогоогүй сул байгаа зэргээс үзвэл өөр газраас зөөж авчирсан байх магадлалтай байна. Анх 2010 онд соёлын өвийн үл хөдлөх дурсгалын тооллого бүртгэлийн ажлын явцад уг хөшөөг баримтжуулан, гар зургийн хамт нийтэлсэн бол (Энхбат нар 2012, 49) он цагийн хувьд Түрэгийн үед хамаарна хэмээн үзсэн (Амартүвшин, Бадма-Оюу 2016, 134) байна. Харин доктор А.Энхтөр уг хөшөөг Түрэгийн түрүү хаант улсын Тоба (Таспар) хаанд уригдаж ирсэн Гандхарагийн лам Жинагуптагийн чулуун хөрөг (Энхтөр 2025, 188) хэмээн нэр оноосон байдаг.

Цацын хотгорын хөшөөнд хоёр гарыг цээжний урд алга хавсран залбирсан нь (*añjali-mudrā*) бишрэл хүндэтгэлийн илэрхийлэл бөгөөд буддын шашны бурхдад түгээмэл байдаг мутарлаг юм. Тиймээс уг хүн чулууг бурхны шашны зарим бэлгэдлийг агуулсан дурсгал хэмээн үзэж болох ба он цагийн хувьд одоогоор яг тодорхой харьцуулан хэлэх баримт үгүй байна. Гэвч Түрэг, Уйгур болон дундад зууны үеийн хөшөө чулуунаас эрс ялгаатай байхын зэрэгцээ дүрслэлийн зарим бэлгэдлээрээ Ингэт толгой хөшөө чулуутай төстэй тул ойролцоо цаг хугацаанд хамаарах болов уу хэмээн таамаглав. Гагцхүү цаашид уг хөшөөний анх байрлаж байсан газрыг олж тогтоож малтлага судалгаа хийснээр он цагийн асуудлыг найдвартай хэлэлцэх боломж бүрдэнэ хэмээн найдаж байна.


**Ингэт толгойн хөшөө анх хаана байрлаж**



**байсан бэ?** Дээр дурдсан өмнөх судалгааны тайлан болон нутгийн иргэдийн өгсөн аман мэдээ, түүхэн гэрэл зураг зэрэг эх сурвалжуудыг шүүж, нэгтгэн үзвэл хүмүүс нууцаар тахиж шүтэн мөргөдөг гэсэн шалтгаанаар 1954 онд сургуулийн хүүхдүүдээр ухаж гаргуулан Сэлэнгэ мөрний урд тохойд авчирч хаясан байсныг нэрт эрдэмтэн Б.Ринчен гуайн зөвлөснөөр сургуулийн хашаанд аваачиж босгожээ. Ямартай ч 1964 онд О.Сэр-Оджав нарын судлаачдыг очиж үзэхэд сургуулийн хашаанд босоо байдалтай байсан ба 1973 оны дундуур дахин буулгаж трактораар чирч одоогийн байгаа Ингэт толгойн баруун урд бэлд авчирчээ. Ийнхүү бидэнд мэдэгдэж буйгаар уг хөшөө чулууг 1950-иад оноос хойш дор хаяж 3 удаа зөөсөн ба одоогийн байгаа байршил нь түүний анх босгосон газар гэж үзэхэд эргэлзээтэй байна.

Бид хээрийн судалгааны ажлын явцад Ингэт толгойн өвөр бэлээр хөшөө байрлаж байсан байж болох газрыг хайж үзсэн боловч социализмын үед сангийн аж ахуйн түлшний агуулах, гахай тахианы байр, хүнсний ногооны зоорь зэргийг барьж байгуулан унаган төрхийг ихэд алдагдуулжээ. Харин одоогоор байж болох хамгийн боломжит хувилбар бол хөшөөнөөс зүүн хойш 65 метрийн зайд толгойн орой дээр орших нэгэн байгууламж юм. Уг байгууламж нь Ингэт толгойн орой дээр шороо дагтаршуулах (hangtu) аргаар өндөр суурь хийж байгуулсан тахил тайлгын сүмбөгөөд бидний таамаглаж буйгаар хөшөө чулуу анх сүмийн урд зүүн урагш харсан байдалтайгаар оршиж байсан хэмээн үзэж байна. Байгууламжийн гол хэсэгт

6.4 х 6.3 метр хэмжээтэй дөрвөлжин хэлбэрийн 2 чулуун суурь илэрсэн ба эдгээрийн дунд талын тасалгааны үзүүрт зүүн урагш хандуулан тавьсан гэрэлт хөшөөний суурь болох чулуун яст мэлхий анхны байрандаа илэрсэн. Харин уг яст мэлхийнээс зүүн урагш тодорхой зайд газрын өнгөн хөрсөн дээр хэсэг чулуу овоолсон жижиг хонхор байсныг бид үүрэг зориулалтыг тодруулах үүднээс малтан судалсан юм. Малтлагын 1-р үед 2.6 х 2.4 м хэмжээтэй дугуй хэлбэрийн чулуун дараас илэрсэн ба цэвэрлэгээнээс дээврийн ваарны хагархай, Манжийн Тэнгэр тэтгэгч хааны үеийн хүрэл зоос, орчин үеийн зоосон мөнгө зэрэг ихээр гарч байснаас үзвэл сүүлд босгосон жижиг овоо байжээ. Малтлагын дараагийн үед чулууг авч өргөргийн дагуу зүсэлт хийж доош малтахад 40 см-ын гүнээс байгалийн том хад гарч улмаар хадны өмнө талаас 2.5 м урт, 0.8 м өргөн зөөлөн бор шороон хөрстэй толбо мэдэгдсэн юм. Толбыг дагуулан доош малтахад нүхний хойд хана бүхэлдээ байгалийн хад байсан бол зүүн болон баруун хэсгээрээ нүхний хэлбэр нь нэлээд эвдэгдсэн шинжтэй байв. Харин нүхэн дотроос дээврийн ваарны хагархай хэсгүүд, дугуй хэлбэртэй шавар эдлэл зэрэг хойд талын барилгын нуранги, ёроол хэсгээс малын ясны хугархайнууд илэрсэн. Мөн нүхний зах хэсгүүдээс тодорхой зохион байгуулалтгүй чулуу ихээр гарч байв. Улмаар малтлагын гүн 1.5 м болоход байгалийн хөрс гарч малтлагын ажлыг дуусгасан юм (Зураг 7).



1- Баруун барилга 3- Мэлхий чулуу  
2- Зүүн барилга 4- Хөшөөний нүх

Зураг 7. Ингэт толгойн орой дээрх чулуун байгууламжийн зураг



Ерөнхийдөө уг нүхний үүрэг зориулалтыг бүрэн тодорхойлох зохион байгуулалт мэдэгдээгүй боловч байршлын хувьд ихээхэн сонирхолтой байна. Тухайлбал уг нүх нь мэлхий чулууны зүүн урд талд 4 метрийн зайд, урд хэрмийн төв хаалгыг чиглэн байрлах ба нүхний хойд хананд таарч буй байгалийн хадыг ашиглан Ингэт толгойн хүн чулууг анх босгож байрлуулсан байж болох юм. Хожим уг байгууламж халдлагад өртөн шатаагдаж нурах үед хүн чулууг тойруулан ухаж гаргах явцад нүхний хэмжээ томорсон бололтой. Учир нь хүн чулуун хөшөөний дээлийн хормой хэсгээс доош газарт суулгах ёзоор нь 70 см урт ба нийт өндөр нь 290 см болох юм. Тиймээс ийм өндөр, хүнд жинтэй хөшөө чулууг сайтар суулгах үүднээс гүн нүх ухаж, ар талд нь байгалийн хадыг ашиглан түшүүлж хоёр хажуу, урд талаас нь чулуугаар чигжжээ. Нүхний ёроол хэсэгт барилгын хэрэглэгдэхүүнтэй хамт холилдож булагдсан малын яснаас авсан дээжинд хийсэн он цаг тогтоох судалгаагаар 773calAD-886calAD(95.4%) хэмээн гарсан нь НТ VIII-IX зууны үед холбогдох баримжаа өгч байна. Энэ нь Ингэт толгойн хөшөө чулууг Уйгур эсвэл Киргизийн хаант улсын үед унагааж эвдсэн байж болзошгүй гэсэн бидний таамаглалтай таарч байгаа юм. Өөрөөр хэлбэл бид шинжилгээнд илгээсэн дээж нь уг тахилын цогцолбор байгууламж нурж, хаягдсан үеийн он цагийн хамаарлыг тодорхойлж байгаа болно.

1931 онд төвөд хэлээр бичсэн Алтан дэвтэрт өгүүлснээр “...Киргизүүд хот балгадыг эвдэн сүм хийдийг шатаан, дээрэм тонуул хийсний ул мөр нь Орхоны Хар балгас, Сэлэнгийн Баян балгас болон түүний ойролцоох Зуугийн сүм, Их эрдэнэ зуу мөн” (Зава Дамдин 2018, 54) хэмээн өгүүлснээс үзвэл тэрбээр хятад сурвалжуудыг сайтар ашигласан нь харагддаг. Учир нь дээр дурдсан дурсгалуудаас Зуугийн сүмээс бусад газруудад археологийн судалгаа хийж Уйгурын үеийн соёлт давхаргыг их бага хэмжээгээр агуулсан болох нь нэгэнт батлагдсан бөгөөд Киргизүүд Уйгурын хот балгадыг тонон дээрэмдсэн тухай сурвалжийн мэдээ үүнийг давхар баталдаг.

### Хэлэлцүүлэг

Өгүүлэн буй сэдвийн хүрээнд судалгааны хэлэлцүүлгийг монгол оронд бурхны шашин дэлгэрсэн түрүү үеийн түүх болон Ингэт толгойн хөшөөнд холбогдох зарим дурсгалын хүрээнд хийсэн болно. Бурханы шашин нь НТӨ VI-V зууны үед Энэтхэг оронд үүсэж улмаар Ашоко хааны үед төрийн шашин болж хөгжсөнөөр голлох урсгалууд Дундад Азийн олон оронд түгэн дэлгэрэх үндэс суурь тавигдсан түүхтэй. Дундад оронд НТӨ I зууны төгсгөл орчимд торгоны замаар Юэчжи нараар дамжин нэвтэрсэн хэмээх үзэл

давамгайлдаг ба улмаар нүүдэлчдийн оролцоотой байгуулсан 16 улсын үед хүчтэй дэлгэрчээ (任继愈1981, 91). Харин Монгол оронд хэрхэн дэлгэрсэн тухай түүхийн асуудлыг Зава Дамдин гавжийн “Алтан дэвтэр” зэрэг бүтээлд анхдугаар, завсрын, хожуу хэмээн гурван өөр цаг хугацаанд гурвантаа дэлгэрсэн болохыг түүхэн сурвалж бичгийн мэдээнд тулгуурлан гаргасан тул эрдэм шинжилгээний хувьд чухал ач холбогдолтой билээ. Алтан дэвтэрт дурдсанаар “Бурхан багш гаслангаас нөгчсөнөөс мянга гурван зуу гаруй жилийн хойно, Хятадын Тан хаан Тантайзун болон Төвөдийн номын хаан Соронзангамбу тэргүүтнээс ялимгүй өмнө үед Монгол орны төв ба доод хэсэгт хаан төр тогтож, Бурхны шашин түгэн дэлгэрсэн. Тэр үед Хятад, Төвд оронд бурхны шашин дэлгэрээгүй байсан ба Монгол орны дээд доод дунд гурван орны алинд ч Ли орноор дамжин дэлгэрсэн” хэмээн бичжээ (Зава Дамдин 2018, 53-55). Ли орон нь одоогийн Ланжоу, Хотон, Дээд Монгол орчмын газар орон байх боломжтой хэмээн Зава Дамдин, Ш. Бира, Л. Хүрэлбаатар нарын эрдэмтэд үздэг (Цэрэнсодном 2010, 17-18). Уг газар нутаг нь ерөнхийдөө торгоны замын гол бүс нутаг болох Хэси-гийн коридор (河西走廊) орчим ба Энэтхэгээс Дундад Азийн Пакистан, Афганистанд дэлгэрч тэндээсээ торгоны замаар дамжин баруун урд талаасаа Монгол нутагт дэлгэрсэн байх магадлал өндөр юм.

Харин түрүү үеийн дэлгэрэлтийн түүхэнд хамаарах сурвалжийн мэдээ байх боловч түүнийг хангалттай батлах археологийн бодит олдвор хэрэглэгдэхүүн одоо хүртэл хомс хэвээр байна. Гагцхүү сурвалжид дурдагддаг НТӨ 121 онд Хүннүгийн Сютү ванг довтлон алтан хүн олзлон авсан тухай мэдээнд тулгуурлан бурхны шашин Хүннү улсын хязгаар нутагт нэвтрэн орсноос биш цааш гүн дэлгэрээгүй хэмээх үзэл үнэнд илүү нийцнэ (Сүхбаатар 2000). Учир нь одоогийн байдлаар Хүннүгийн үед хамаарах 10 гаруй хот суурин, мянга гаруй булшийг малтан судлаад буй боловч тэндээс бурхан шашны холбогдолтой олдвор бараг олдоогүй болно. Харин хүннүгийн язгууртны булшнаас гарсан Грек-Бактри гаралтай хэмээн үзэж буй нэхмэл эдлэлүүдийн хээ чимэглэлийг илүү өргөн хүрээнд харьцуулан судлах шаардлагатай (Эрэгзэн 2022, 20).

1930-аад онд Зава Дамдин гавж монгол нутагт бурхны шашин дэлгэрсэн цаг хугацааг анхдугаар, завсрын, хожуу хэмээн ангилж дараах байдлаар тоймлон авч үзжээ. Үүнд:

1. Эртний үе буюу өвөг Монголын үе (Хүннүгээс Хятаны үе)
2. Монголын үе (XIII-XIV зуун)
3. Эзэнт гүрний дараах үе (XV-XVII зуун) (Бира 2010, 8-11)

Бидний энд өгүүлэн буй Ингэт толгойн хөшөө чулуу нь биеийн ерөнхий хэлбэр, дүрслэлийн олон шинжээрээ бурхны шашны анхдугаар дэлгэрэлтийн түүхэнд холбогдох чухал дурсгал хэмээн үзэж буй бөгөөд он цагийн хувьд НТ V-VI зуунд хамаарна хэмээн үзэж байна. Түүхэн сурвалжаас үзвэл Жужанчуудын дунд бурхны шашин төрийн шашин болох хэмжээнд дэлгэрч байсныг манай ахмад эрдэмтэд олон баримтаар нотлон бичсэн байдаг (Сүхбаатар 1992, 128-136). Эдгээрийн дотроос зарим чухал мэдээг дурдвал Өмнөд Ци (479-502) улсын хувраг Фай Ай (法爱)-г Жужаны улсын багшаар томилж, гурван мянган өрх соёрхсон тухай мэдээ “Нэрт хуврагуудын шастир (高僧传)”-ын 8-р бүлэг дэх Фа Ай-гийн намтарт тэмдэглэн үлдээжээ (释慧皎 1992, 312). Энэ нь Жужан улсын үед бурханы шашин зөвхөн ард иргэдийн сүсэг бишрэлийн түвшинд бус, төрийн бодлогоор дэмжин дэлгэрүүлж байсныг илтгэх баримт юм.

Шашин дэлгэрүүлэх явдал нь тухайн ард түмнийг оюун санааны хувьд нэг үзэл, итгэл үнэмшлээр нэгтгэн захирах хаадын төрийн бодлоготой шууд холбоотой бөгөөд сүм хийд байгуулах, бурхны дүр бүхий хөшөө дурсгал, уран баримал бүтээх, судар ном бичиж туурвих, орчуулах зэрэг үйл ажиллагаагаар илэрч байжээ.

Жужаны хаант улстай мөр зэрэгцэн оршиж байсан баруун өмнө болон өмнө талын хөрш улсуудад бурхны шашин хүчтэй дэлгэрч гадаад орчны нөлөө их байсан агаад хаад язгууртнууд өөрсдийгөө ард түмэнд бурхан мэт тахин шүтүүлэх зорилгоор аварга том хэмжээтэй бурхдыг бүтээлгэж байсан уламжлал олон байдгийн нэг нь НТ 454 онд бүтээгдсэн Умард Вэй улсын 5 хааны дүр бүхий хадан агуй дахь бурхны баримлууд юм. Үүнтэй адил Ингэт толгойн хөшөөг ч тухайн үеийн хаад язгууртны төлөөлөл өөрийн царай төрхийг шингээн бурхны дүр байдлаар бүтээсэн байж болох юм. Умард Вэй улсын судрын Жужаны бүлэгт Юнпингийн 4-р оны (511) 9-р сард Чону хаан хувраг Суанфэн (宣奉)-ийг илгээж сувдан бурхан өргөн барив гэсэн мэдээ байхын зэрэгцээ Жужаны хаадын дотор Богд, Брахман зэрэг бурхны шашны холбогдол бүхий нэрс бий. Жужанд дэлгэрсэн бурхны шашин Түрэгийн түрүү үеийн хаант улсын үед залгамжлан дэлгэрч, Таспар хааны зарлигаар судар ном орчуулах, сүм хийд байгуулсан тухай мэдээнээс үзвэл энэ үйл явц VII зууны эхэн хүртэл эрчимтэй явагдсан дүр зураг ажиглагдаж байна.

Бурхан багшийг босоо байдлаар урласан хөшөө дурсгал Дундад Азийн бүс нутаг, БНХАУ-ын газар нутагт олон тоогоор хадгалагдан үлджээ. Эдгээр дотроос Ингэт толгойн хөшөөтэй бүс нутгийн хэмжээнд хамгийн ойр байрлалтай

төдийгүй дүр төрхийн хувьд ижилсэх олдвор бол ОХУ-ын Буриадын нутаг дахь Иволгын суурины ойролцоогоос 1927 онд түүврээр олдсон нэгэн хүрэл эдлэл юм. Уг эдлэл нь бадам цэцгэн суурин дээр ардаа гэрлийн цацрагтай, зогсоо байдлаар урласан гурван бурхны дүрслэлтэй. Гол онцлог нь гэрлийн цацрагийн ар талд 7 мөр 57 ширхэг ханз утга үсэгтэй бөгөөд бичээсийг 1957 онд Э.П.Рыгдылона тайлж уншин НТ 441 онд холбогдуулан үзсэн байдаг (Рыгдылона 1957, 139-143) (Зураг 8).

Иволгын суурингаас олдсон уг эдлэлийн хятад бичээсийг Японы эрдэмтэн Тэцу Масумото дахин уншиж холбогдох он цагийн тухайд өмнөх судлаачдын саналыг ерөнхийд нь дэмжсэн байдаг. Харин бичээсийн утга, эдлэлийн үүрэг зориулалт болон тухайн үеийн түүхэн нөхцөл байдлын талаар зарим саналыг дэвшүүлжээ. Иволгоос олдсон эдлэлийн ар талд буй бичээст “Гурван Майдар Бодисадва” хэмээн дурдсаныг үзвэл Майдар бурхныг дүрсэлсэн гэдэг нь илт байна гэжээ. Ерөнхий дүрслэлийн хувьд бадам цэцгэн суурин дээр босоо байдлаар урласан ба толгойн орой хэсэгт овгор байдлаар үснир, баруун гарыг тохиогоор нугалж алгыг урагш харуулсан Абая мутар, зүүн гарыг бугуйгаар нугалж алгыг урагш харуулсан Варада мутар бүхий урт хормойтой номт дээлтэйгээр дүрсэлжээ (Тэцу Масумото 2011, 355-361). Бичээсийн ерөнхий утга агуулгын хувьд Умард Вэй улсын Тай Уди хааны 2-р онд сүсэгтэн Жаотун хэмээх хүн гурван майдар бодисадва бурхан бүтээлгэх болсон учир нь насан өөд болсон эцэг эх, одоо амьд сэрүүн байгаа гэргий хүүхдийнхээ сайн сайхны төлөө хамаг амьтан бүгдээр буян хишгийг хүртэж, энх амар жаргахыг тухайд зориулсан ажээ. Умардын төрийн үед сүсэгтэн олон бурхдын дүрт баримал захиалж буян хийх уламжлал нэлээд түгээмэл байсан болохыг хятадын нутгаас олдсон Умард Вэй, Умард Чи улсын үеийн олдвор болон түүн дээрх бичээсээс тод харагддаг. Энэ төрлийн жижиг хэмжээтэй шавар, чулуу, алт, хүрэл зэрэг материалаар урласан бурхдын дүр бүхий баримлыг ихэвчлэн сүсэгтэн олны захиалгаар бурхан болсон төрөл төрөгсдийнхөө хойдын насны буяны үйлд зориулан урладаг уламжлалтай байжээ.

Ерөнхийдөө Иволгоос олдсон хүрэл баримал дээрх бурхдын ерөнхий төрх, үснир, гарын мутарлаг, номт дээл зэрэг нь дүрслэлийн олон шинжээрээ Ингэт толгойн бурхны дүрт хөшөөтэй ижил байна. Ялангуяа нүүрний ерөнхий төрхийг махлагдуу, хацар булцгар элбэг дүүрэн, амар амгалан байдлыг илтгэсэн шинжээрээ ихэд төстэй. Харин анхаарал татаж буй нэгэн зүйл бол арын бичээст “Гурван Майдар бодисадва” гэж бичсэнээр уг бурхдыг шууд майдар хэмээн





Зураг 8. Иволгоос олдсон Бурхан багшийн босоо дүр бүхий хүрэл эдлэл (НТ 441 он)

ойлгож болохгүй мэт санагдана. Учир нь эртний Энэтхэгийн Гупта улсын үеийн Матхара болон Сарнат хэв маяг, Умардын төрийн үеийн Цинжоугийн бүс нутгаас олдсон бурхан багшийн хөшөө баримал дахь үсний засал, хоёр гарын байрлал, дээл хувцас зэрэгтэй харьцуулан харахад Иволгоос олдсон баримал нь бурхан багшийг дүрсэлсэн хэмээн үзэх үндэслэл бий. Судалгааны материалуудаас шүүн харахад Умард Вэй улсын сүүл үед бүтээгдсэн алтан шармал, хүрэл, чулуун баримлуудын ар талын бичээс дэх нэр нь уг бурхантай нийцдэггүй тохиолдол олон байдгийг хятадын судлаачид онцлон тэмдэглэжээ. Бичээст Арьяабал бурхан бүтээлгэв гэсэн байхад баримлын уг дүр нь аюулгүй болон өглөгийн мутартай Бурхан багш, мөн эсрэгээрээ бичээст Бурхан багш бүтээлгэв гэсэн бол баримал нь Бодисадва байх 10 гаруй тохиолдол байдаг (何志国2021, 130).

Тиймээс дээрх хүрэл эдлэл нь “Бурхан багшийн дүр төрхөөр төлөөлүүлэн, сургаал номлолыг нь залгамжлагч ирээдүйн сайн цагийн Будда болох бодьсадва/Майдарын бэлгэдлийн илэрхийлэл гурван цаг, “гурван дүрийн шүтээн” (*triad*)-ний хамгийн эрт үед холбогдох олдвор хэмээн үзэж болно. IV-V зууны үед бурхдын дүр, дүрслэлийн төрөл, ялгаа сонгодог хэлбэрээр тогтоогүй, Бурхан багшийн нийтлэг дүрслэл зонхилж байжээ.

Бурхан багшийн дүрийг бүтээж ирсэн түүхэн уламжлалаас харахад газар орон бүрд харилцан адилгүй бөгөөд энэ нь тухайн үед дэлгэрч байсан бурхны шашны урсгал чиглэлтэйгээ

нягт холбоотой аж. Анх Бурхан багшийн чандар шүтээнийг суварга болгон бүтээж түүний ариун намтрыг харуулсан хүүрнэл бүхий дүрүүдийг чимэглэл байдлаар урлаж байсан бол НТ II зууны дунд үеэс эхлэн босоо болон суугаа дүрээр хөшөө чулуунд эсвэл зоосон мөнгө дээр дүрслэх явдал түгээмэл болжээ. Энэ нь их хөлгөн буюу Махаяна урсгал чиглэл Кушаны хаант улсын үед Гандхара болон Матхура зэрэг бүс нутагт дэлгэрч эхэлсний тэмдэг хэмээн үздэг (Kurt A. Behrendt 2007, 47-48).

Судлаачдын үзэж буйгаар НТ IV-V зууны үед Энэтхэгийн Гупта улсын үед Бурхны шашин далайн замаар дамжин Зүүн өмнөд Ази болон Хятадын зүүн хэсгийн Цинжоугийн бүс нутагт тархсан ба үүнд хутагт лам нар чухал нөлөө үзүүлжээ. Учир нь дээр дурдсан бүс нутгаас олдсон бурхдын босоо дүр, хувцас чимэглэлд Гандхара хэв маяг түлхүү ажиглагдахын зэрэгцээ (Kurt A. Behrendt 2022, 111-112) биед наалдсан нимгэн нөмрөг бүхий номт хувцас бүхий орон нутгийн онцлогтой Цинжоу хэв маяг үүсэж, цааш Лоян зэрэг газруудад тархжээ (Shuangqiao Meng and Peining Li 2023, 15). Ингэт толгойн хөшөөг харьцуулан үзсэн Хятадын судлаач Шүчи зарим сонирхолтой таамаглалуудыг дэвшүүлсэн байдаг. Түүний үзсэнээр Ингэт толгойн хөшөө нь бурхан багшийг босоо байдлаар урласан хөшөө мөн ба ийм том хэмжээтэй бурхдыг ихэвчлэн сүмийн дотор залсан байдаг гэжээ. Мөн том толгой, богино хүзүүтэй байгаа нь нүүдэлчдийн уугуул төрхийг онцлон тусгасны шинж ба хувцасны

хуниас биеийн ихэнх хэсэгт харагдахгүй биед наалдсан мэт нимгэн байгаа нь Энэтхэгийг Гупта улсын үеэс уламжлалтай Сарнат хэв маяг бөгөөд уг уламжлал далайн замаар дамжин Хятадын Цинжоугийн бүс нутагт тархсан гэж үздэг. Харин зөвхөн мөрний хэсэгт зарим хуниасыг тод гаргаснаараа Цинжоугийн бүс нутагт тархсан Умард Чи улсын үеийн бурхны дүрүүдтэй төстэй байгаа тул холимог шинжийг агуулсан хэмээн дүгнэжээ (Хучи 2025, 175-185).

**Ингэт толгойн хөшөөний он цагийн асуудал.**

Ингэт толгойн хөшөөний холбогдох он цагийн тухайд манай ахмад эрдэмтэд хээрийн судалгааны явцад тулгуурлаж өөр өөрсдийн саналыг дэвшүүлсэн байдаг. Анх 1964 онд Н.Сэр-Оджав хөшөөний он цагийн тухайд *“Тэрхүү чулууны хийц байдлыг үзэхэд түрэгийн үеийн хүн чулуу лав биш, харин нэлээд хожуу үеийнх бололтой байна. Нэгэнт хүн чулууны байсан булш эвдэгдсэн, тоногдсон учир түүнийг нарийвчлан судлах үндсэн ганц зам нь бусад хүн чулуудтай харьцуулан жишээлэх арга болно”* гэжээ (Сэр-Оджав 1965, 62). Мөн тэрээр хожим хэвлүүлсэн *“Эртний Түрэгүүд”* бүтээлдээ А.Позднеевын Өвөр Монголын Түмэд хошуу, А.П.Окладниковийн Уссурийск хотын орчмоос олдсон хөшөө чулуудтай харьцуулан үзэж XII-XVI зууны үед холбогдуулан үзжээ (Сэр-Оджав 1970, 62). Дээр дурдсан хөшөө чулууд нь босоо байдлаар урласнаас биш толгойн хэлбэр, гарын байрлал, хувцас зэрэг дүрслэлийн олон шинжээрээ Ингэт толгойн хөшөөнөөс эрс өөр юм.

Ингэт толгойн хөшөөний хэлбэр байдал, өмссөн хувцас зэрэг нь Монгол нутгаас олдсон Түрэг, Уйгур, Монгол гүрний үеийн хүн чулуудаас өөр бөгөөд дээл, малгайн хэлбэрийг ажиглахад

өмнө зүгийн нангиадын бомбын сурталт хувраг хүний хувцас мэт бөгөөд Ингэт хэмээх нэр нь их хаадыг оршуулж тахилга хийх зан үйлд гардаг ботго алж ингэ буйлуулах домог, хөшөөний дэргэд байгаа чулуун овоолго дээр байгаа доороо хөлтэй ширмэн цөгц зэрэгт тулгуурлан Кидан улсын үеийн дурсгал ч байж болзошгүй хэмээн дүгнэсэн байдаг (Баяр 1990, 8-9). Тухайн үеийн түүхэн нөхцөл байдлаас үзэхэд Хятан нарын хил хязгаарын хойд зах нь Туул голын хөндийгөөр зааглагдаж байсныг анхаарах нь зүйтэй бөгөөд ширмэн цөгцний хувьд шууд хөшөө чулуутай холбоотой гэж үзэхэд эргэлзээтэй юм.

2023 оноос эхлэн хэрэгжүүлж буй “Өв соёлын голомт” төслийн хүрээнд Ингэт толгой орчимд хийсэн судалгааны ажлын үр дүнд тулгуурлан Ингэт толгойн хөшөө чулуу нь үсний засалт, нүүрний төрх, мутрын байрлал, хувцасны засал зэргээрээ бурхан багшийн дүр төрхтэй төстэй хэмээн дүгнэжээ (Цогтбаатар 2023) судалгааны хэлэлцүүлэгт дахин оруулжээ. Түүнчлэн толгойн орой дээрх байгууламжийн малтлагаас гарсан барилгын дээврийн нүүр ваарны хээ чимэглэлд тулгуурлан дурсгалын холбогдох он цагийг Жужаны төгсгөл Түрэгийн түрүү хаант улсын үед холбогдуулан үзсэн (Содномжамц 2024, 39-40) юм.

Ингэт толгойн хүн чулуу нь хэдийгээр анхны байрлалаас хөдөлсөн боловч түүний дүрслэлийн онцлог байдлыг бусад газраас олдсон хөшөө чулуудтай харьцуулан үзэж он цагийн баримжааг гаргах боломжтой. Харин Ингэт толгойн орой дээрх байгууламж болон түүний өмнө талаар илэрсэн нүх зэрэг нь уг хөшөөний үүрэг зориулалт, он цагийг тогтооход чухал эх сурвалж болно.



Зураг 9. Бурхан багшийн босоо дүр бүхий Матхура болон Цинжоу хийцийн хөшөөд (HT V-VI зуун). а, б. Энэтхэг, Уттар Прадеш, Матхура (V зуун). с. Хятад, Шандун, Цинжоу сүм (Умард Вэй 500-534), d. Цинжоу сүм (Умард Чи 550-577), f. Булган, Сэлэнгэ, Ингэт толгой (V-VI зуун)

Уг хөшөөг Ингэт толгойн орой дээрх тахилгын сүмийн үүдэнд байсан хэмээн үзвэл сүм рүү нэвтэрч орох хаалганы өөдөөс харан байрлаж буй нь тахилч, мөргөлчдөд сүр жавхлантай сэтгэгдэл төрүүлэх зорилгоор зориуд хүний нүдэнд ил тусах байрлалыг сонгон босгосон байж болно. Ингэт толгойн хөшөө чулуу нь үсний, баруун зүүн гарын байрлал, хувцас болон босоо байдлаар урласан шинжээрээ Энэтхэгийн Уттар Прадеш мужийн Матхурагаас олдсон V зууны Буддагийн босоо дүр, Хятадын Шандун мужийн Цинжоу хотын Лунсин сүмээс олдсон Умард Вэй, Зүүн Вэй, Умард Чи улсын үеийн шавар болон чулуугаар урласан Буддагийн дүрүүдтэй төстэй байна (中华 2002, 42; 144) (Зураг 9).

Харин Ингэт толгойн хөшөөнд хөл, хувцасны энгэрийн хуниас, ар талын гэрлийн цацраг зэргийг нарийн дүрслээгүй. Гэхдээ хувцасны хуниасыг мөрний хэсэгт бага зэрэг гаргаж, энгэр хэсэгт улаан зосоор ханан хээ зурсны зэрэгцээ богино хүзүүтэй, царайг нь нүүр дүүрэн махлаг байдлаар урласныг нүүдэлчдийн ахуй байдлыг шингээсэн бүс нутгийн онцлог шинж хэмээн үзэж байна. Жужанчууд нь өмнөд хөршийн Умард төрийн улс болон баруун зүгийн орнуудтай дайн тулаан, худалдаа наймаа болон ураг барилдах зэргээр өргөн харилцаж байсан олон баримт бий. Ялангуяа НТ V-VI зууны эхэн хагаст Турфан, Таримын бүс нутагт эрхшээл нөлөөгөө тогтоон, торгоны замын гол зангилаа хэсгийг хянаж байсан төдийгүй Гаочанаас Бархөлөөр дайран Тэнгэр уулын зүүн хэсэг Богд уулыг даван Монголын төв нутагтай холбодог зам нь хожим сурвалжид “хуйхуй зам” (Уйгурын зам) нэрээр алдаршсан байдаг (Дэлгэржаргал 2020, 22). Дээр дурдсан түүх болон археологийн эх сурвалжуудаас үзвэл Монголын төв болон умард бүс нутагт багадаа НТ IV-V зуунаас Бурхны шашин нэвтрэн, дэлгэрч байсан нь тодорхой мэдэгдэнэ. Харин Бурхны шашны ямар урсгал, аль чиглэлээр хэрхэн нэвтэрч байсан талаар одоогоор тодорхой хэлэх баримт хангалттай бүс боловч Бугат болон Хүйс толгойн согд, брахми бичээс бүхий дурсгалаас үзэхэд өрнө зүгийн нөлөө түлхүү ажиглагдах шинжтэй байна. Уг асуудал цааш цаашдын олон баримтаар нөхөгдөж Монгол нутагт Бурхны шашин дэлгэрсэн түүх илүү тодорхой болно гэдэгт найдаж байна.

### Дүгнэлт

Булган аймгийн Сэлэнгэ сумын Ингэт толгойн дурсгалт газарт хийсэн археологийн судалгааны үр дүнд тулгуурлан уг байгууламж нь тахилгын сүм, бурхан багшийн хөшөө, сууц зэргээс бүрдэх цогцолбор дурсгал нь болох нь тодорхой мэдэгдэж байна. Энэ нь Монгол нутаг дахь эрт үеийн Бурхны шашны түүх, нүүдэлчдийн соёл, зан

заншил, амьдралын хэв маяг зэрэг олон асуудлыг лавшруулан судлахад чухал хэрэглэгдэхүүн болох юм.

Ингэт толгойн орой дээрх байгууламжийн байршил, ерөнхий төлөвлөлт болон тэндээс гарсан олдворын цогц байдлаас үзэхэд олон нийтэд зориулсан сүм хийд биш харин хаад язгууртан хүний алдар гавьяаг мөнхжүүлэх, жилийн тодорхой цаг улиралд тахилга хийх зорилгоор босгосон тахилгын сүм байжээ. Хэдийгээр тахилгын сүмийн хоёр барилга их хэмжээгээр тоногдож эвдэрсэн хэдий ч малтлагаас гэрэлт хөшөөний суурь болох чулуун яст мэлхий, хөшөө чулууны нүх, сүмийн хойд талаас хүн байнга сууж байсныг илтгэх ханзан халаалтын систем бүхий сууц илэрсэн. Тахилгын сүмийн малтлагаас гарсан бадам цэцгэн хээтэй нүүр ваар, зээ бадан дүрст толгой ваар зэрэг Бурхны шашны бэлгэдлийг агуулсан барилгын дээврийн хэрэглэгдэхүүн гарсны зэрэгцээ гол дэл нурууны үзүүрт байрлах чивэй чимэглэл нь тухайн барилга өндөр дээд язгууртан хүнд зориулсан болохыг давхар илтгэнэ. Энд дурдсан барилгын чимэглэлтэй ижил төстэй олдворууд Умард, Өмнөдийн төрийн үеийн (420-589) томоохон сүм хийдээс олдсон тул тэдгээр нь дурсгалын харьцангуй он цагийг тогтоох чухал сэжиг болж байна. Тиймээс бид уг дурсгалын он цагийг НТ V зууны төгсгөл, VI зууны эхэн үед байгуулсан тахил тайлгын зориулалтай сүм байсан хэмээн үзэж байна.

Ингэт толгойн хөшөөг янз бүрийн шалтгаанаар хэд хэдэн удаа зөөсөн болохыг археологи болон угсаатны зүйн мэдээ баримт нотлох бөгөөд бидний таамаглаж буйгаар анх Ингэт толгойн орой дээр байрлаж байжээ. Ингэт толгойн хөшөөний тэргүүнд үснийг овгор байдлаар товойлгон урласан бол баруун гар нь дээдийг өгөхийн мутар, зүүн гар нь авралыг өгөхийн мутар бүхий номт дээл өмссөн байдлаар урласан Бурхан багшийн босоо дүр ажээ. Буддын шашин Евроазийн бүс нутагт түгэн дэлгэрэхэд газар орны ахуй соёлд нь нийцүүлсэн бурхдын дүрийг бүтээх уламжлал нийтлэг байсан ба ингэснээр тухайн ард түмний оюун санаанд бат шингэх нөхцөл бүрддэг. Нүүдэлчдийн оюун сэтгэлгээнд хүний царайны элбэг хангалуун, нүүр дүүрэн төрх байдлыг бодолцон урлал хийх уламжлал нийтлэг байсан бөгөөд Ингэт толгойн хөшөөнд энэ байдал тод ажиглагдахын зэрэгцээ энгэр хэсэгт улаан зосон будгаар ханан хээ гаргасан нь бусдаас ялгарах орон нутгийн онцлог аж. Бидний сүүлийн жилүүдэд хийсэн харьцуулсан болон лабораторийн судалгааны үр дүнд тулгуурлан Ингэт толгойн Бурхан багшийн дүр бүхий хөшөөг толгойн орой дээрх тахилгын сүм бүхий цогцолбор дурсгалтай ижил цаг хугацаанд, тухайлбал НТ V-VI зууны үе



буюу Жужаны хаант улсын төгсгөл үед хамаарна хэмээн үзэж байна. Цаашдын нарийвчилсан судалгаа шинжилгээний ажлын үр дүнд дээрх он цагийн хамаарлыг бататгах боломжтой юм.

## НОМ ЗҮЙ

Амартүвшин Ч., Бадма-Оюу Б. Монголын хүн чулуу. *Монголын археологийн өв 6-р боть*. Редактор С.Чулуун, Д.Цэвээндорж, Улаанбаатар, 2016.

Амгалан Н. Ингэт толгой дах хүн чулууг харьцуулан судлах нь. *Буддын шашин ба Археологи олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар, 2024.

Баяр Д. 1990 онд Булган, Сэлэнгэ, Төв аймгийн нутагт ажилласан хээрийн шинжилгээний ангийн тайлан. *ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг*. Улаанбаатар, 1990.

Бира Ш. Монгол дахь Буддын шашны түүхчилсэн тойм. *Лам нарын сэтгүүл*, №3, Улаанбаатар, 2010.

Bunce, Fredrick W. Mudras in Buddhist and Hindu Practices: An Iconographic Consideration. New Delhi: D.K. Printworld, 2009.

Дэлгэржаргал, П. Торгоны замын ноёрхлын төлөөх Жужан улсын тэмцэл. *Historia Mongolarum*, Tom.XIX, fasc.2, Улаанбаатар, 2020, 11-22.

Зава Дамдин Лувсандаян. Их монгол оронд Бурханы шашин дэлгэрсэн түүх “Алтан дэвтэр”. Төвөд хэлнээс орчуулсан С.Гантөмөр. Улаанбаатар, 2018.

Намнандож О. 1953 оны экспедицийн замын тэмдэглэлээс. *Шинжлэх ухаан*, 1956 он №3. II боть, Улаанбаатар, 2003.

Мөнхнаран Н. Их түүхийн зам /Дурсамж, дурдатгал, түүх/. Улаанбаатар, 2023.

Рыгдылон Э.Р. Китайские знаки и надписи на археологических предметах с Селенги // *Записки Бурят-Монгольского научно-исследовательского института культуры*. Улан-Удэ, 1957.

Содномжамц Д., Мөнхбаяр Л., Цогтбаатар Б., Анхсанаа Г., Нандин-Эрдэнэ Н., Ууганбаяр М. “Өв соёлын голомт” төслийн хүрээнд Ингэт толгойн дурсгалт газарт хийсэн археологийн судалгаа. Буддын шашин ба Археологи олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2024.

Сүхбаатар Г. Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар, 1980.

Сүхбаатар Г. Монгол Нирун улс (330-555). Редактор Ч.Далай. Улаанбаатар, 1992.

Сэр-Оджав Н. Монголын төв умар хэсгийг археологийн талаар судлан шинжилсэн нь. *Studia Archaeologica*. Tom. IV, Fasc.7, Улаанбаатар, 1965.

Сэр-Оджав Н. Эртний Түрэгүүд (VI-VIII).

*Studia Archaeologica*, Fasc.2, Улаанбаатар, 1970.

Тэцү Масумото. Бронзовая статуэтка будды из иволги и ее значение в истории забайкалья в V-VI вв. н.э. Древние культуры Монголии и Байкальской Сибири : материалы междунар. науч. конф. (Иркутск, 3-7 мая, 2011 г.) / под общ. ред. А.В. Харинского. Иркутск : Изд-во ИрГТУ, 2011. Вып. 2. 576 с.

Хандсүрэн Ц. Жужаны хаант улс ба түүхийн зарим судалгаа. Улаанбаатар, 2005.

Цогтбаатар Б., Содномжамц Д., Мөнхбаяр Л., Анхсанаа Г., Нандин-Эрдэнэ Н. “Өв соёлын голомт” төслийн хүрээнд Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт 2023 онд хийсэн археологийн малтлага, хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2023.

Цэрэнсодном Д. Монгол орон дахь буддын шашны түрүү үеийн дэлгэрэлтэд холбогдох Ли орны тухай товч тэмдэглэл. *Лам нарын сэтгүүл*, №3, Улаанбаатар, 2010.

Энхбат Г., Даваацэрэн Б., Болд Р. Монгол улсын нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал. VII дэвтэр Булган аймаг. Улаанбаатар, 2018.

Энхтөр А. Эрдэнэ дайчин вангийн хошууны нутаг дахь түүх, соёлын дурсгалууд. *Түүхээт хан аймгийн Эрдэнэ дайчин вангийн хошууны түүх соёл эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл*. Улаанбаатар, 2025.

Эрэгзэн, Г. Хүннүд бурхны шашин дэлгэрч байсан уу?. “Буддын шашин ба археологи” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2022.

Xuchi. Stone buddha on the steppe and the shaping of imperial authority: Transmission of buddhism to the Turkic khaganate during the 6th to 8th century. «Ancient cultures of Mongolia, Baikal, Southern Siberia and Northern China» the 13th international conference. Ulaanbaatar, 2025.

Peter Stewart. Gandharan art and the classical world a short introduction. Archaeopress. 2024. <https://doi.org/10.2307/jj.15135910>

Kurt A. Behrendt. The art of Gandhara in the Metropolitan museum of art. Yale University press, 2007. <https://doi.org/10.32028/9781803272337-5>

Kurt A. Behrendt. Gandhāran imagery as remembered by Buddhist communities across Asia. The Rediscovery and Reception of Gandhāran Art (Archaeopress 2022): 107–123 <https://doi.org/10.32028/9781803272337-5>

Shuangqiao Meng and Peining Li. From the Malay Peninsula to the Shandong Peninsula: The Transmission of Buddha Statues with Tight-Fitting Robe in the Sixth Century. *Religions* 2023, 14, 84. <https://doi.org/10.3390/re14010084>

《北史》卷九十八《蠕蠕》中华书局, 2000 年, 2157页。

《魏书》卷一百三《蠕蠕》中华书局，2000年，1549页。

(梁)释慧皎：《高僧传》卷八《法瑗传》，中华书局，1992年，第312页。

何志国《试论早期佛陀、菩萨像名实不符的现象——以早期金铜佛像为中心》文物研究2021年第一期，130-138页。

任继愈主编：《中国佛教史》[M]第一卷，中国社会科学出版社，1981：91。

中华世纪坛艺术馆、青州市博物馆《青州北朝佛教造像》北京出版社2002年。

## REFERENCES

Amartuvshin Ch., Badma-Oyuu B. “Mongolyn khun chuluu”. [Stone Statue of Mongolia] Archaeological Relics of Mongolia vol. 6. Edited by S.Chuluun, D.Tseveendorj, Ulaanbaatar, 2016.

Amgalan, N. “Inget tolgoi dakh khün chuluug khartsuulan sudlakh ni” [A Comparative Study of the Anthropomorphic Statue at Inget Tolgoi]. Proceedings of the International Scientific Conference on Buddhism and Archaeology. Ulaanbaatar, 2024.

Bayar, D. 1990 ond Bulgan, Selenge, “Töv aimgiin nutagt ajillasan kheeriin shinjilgeenii angiiin tailan” [Report of the Field Research Team in the Territories of Bulgan, Selenge, and Töv Provinces in 1990]. Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Manuscript Fund. Ulaanbaatar, 1990.

Bira, Sh. “Mongol dakhi Buddyn shashny tүүkhichilsen toim” [Historical Overview of Buddhism in Mongolia]. *Lam naryn setgүүл* [Journal of Lamas], no. 3. Ulaanbaatar, 2010.

Bunce, Fredrick W. *Mudras in Buddhist and Hindu Practices: An Iconographic Consideration*. New Delhi: D.K. Printworld, 2009.

Delgerjargal, P. “Torgony zamyn noyorkhlyin tölөөkh Jujan ulsyn temtsel.” [The Struggle for the Silk Road: Rouran and Northern Wei], *Historia Mongolarum*, Tom. XIX, fasc. 2, Ulaanbaatar, 2020.

Zava Damdin Luvsandayan. *Ikh mongol orond burkhany shashin delgersen tүүkh “Altan devter.”* [The History of the Spread of Buddhism in Greater Mongolia]. Translated from Tibetan by S. Gantumur. Ulaanbaatar, 2018.

Namnandorj, O. “1953 ony ekspeditsiin zamyn temdegdelees.” [From the Route Journal of the 1953 Expedition] *Shinjelek ukhaan*, 1956, №3. Vol. II, Ulaanbaatar, 2003.

Munkhnaran, N. *Ikh tүүkhiin zam /Durshamj, durdatgal, tүүkh/*. [The Path of Great History (Memoirs, Recollections, and History)], Ulaanbaatar, 2023.

Sukhbaatar, G. *Mongol Nirun uls (330-555)* [The Mongol Rouran Khaganate (330-555)]. Edited by Ch. Dalai. Ulaanbaatar, 1992.

Ser-Odjav, N. “Mongolyn töv umar khesgiig arkheologiin talaar sudlan shinjilsen ni [Archaeological Research in the North-Central Part of Mongolia.]” *Studia Archaeologica*, Tom. IV, Fasc. 7, Ulaanbaatar, 1965.

Ser-Odjav, N. *Ertanii Türegүүд (VI-VIII)* [The Ancient Turks]. *Studia Archaeologica*, Fasc. 2, Ulaanbaatar, 1970.

Tsogtbaatar, B., Sodnomjamts D., Munkhbayer L., Ankhsanaa G., and Nandin-Erdene N. “Öv soyolyn golomt” tösliin khürend Bulgan aimgiin Selenge sumyn nutagt 2023 ond khiisen arkheologiin maltlaga, khaiguul sudalgaany ajlyn tailan [Report on Archaeological excavations conducted in Selenge soum, Bulgan province, Ulaanbaatar, 2023].

Rygdylon, E. R. “Kitayskiye znaki i nadpisi na arkheologicheskikh predmetakh s Selenge” [Chinese Signs and Inscriptions on Archaeological Artifacts from the Selenge River]. In *Zapiski Buryat-Mongol'skogo nauchno-issledovatel'skogo instituta kul'tury*. Ulan-Ude, 1957.

Sodnomjamts, D., L. Mönkhbayer, B. Tsogtbaatar, G. Ankhsanaa, N. Nandin-Erdene, and M. Uuganbayer. “Öv soyolyn golomt” tösliin khürend Inget tolgoi dursgal gazart khiisen arkheologiin sudalгаа.” In *Proceedings of the International Scientific Conference on Buddhism and Archaeology*. Ulaanbaatar, 2024.

Masumoto, Tetsu. “Bronzovaya statuetka buddy iz ivolgi i eye znachenie v istorii zabaykal'ya v V-VI vv. n.e.” [Bronze Statuette of Buddha from Ivolga and its Significance in the History of Transbaikalia in the 5th–6th Centuries AD]. [Ancient Cultures of Mongolia and Baikal Siberia: Proceedings of the International Scientific Conference (Irkutsk, May 3–7, 2011)], edited by A. V. Kharinskiy, Vol. 2. Irkutsk: Izd-vo IrGTU, 2011.

Khandsuren, Ts. *Jujany khaant uls ba tүүkhiin zarim sudalгаа* [The Rouran Khaganate and Some Historical Research]. Ulaanbaatar, 2005.

Sukhbaatar, G. *Mongolchuudyn ertanii övөг* [Ancient Ancestors of the Mongols]. Ulaanbaatar, 1980.

Tserensodnom, D. “Mongol oron dakh Buddyn shashny түрүү үеийн delgerelt kholbogdokh Li orny tukhai tovch temdegel” [Brief Notes on the Li Country Related to the Early Spread of Buddhism in Mongolia]. *Lam naryn setgүүл*, no. 3 (2010).

Enkhbat, G., Davaatseren B., and Bold R. *Mongol ulsyn nutag dakh' tүүkh, soyolyn үл khөdlөkh dursgal. VII devter: Bulgan aimag* [Immovable Historical and Cultural Monuments in the Territory of Mongolia. Vol. VII: Bulgan Province]. Ulaanbaatar, 2018.

Enkhtur, A. “Erdene daichin vangiiin khoshuuny nutag dakh tүүkh, soyolyn dursgaluud” [Historical and Cultural Monuments in the Territory of Erdene

Daichin Wang Banner]. In *TüsHEET khan aimgiin Erdene daichin vangiin khoshuuny tiiikh soyol conference proceedings*. Ulaanbaatar, 2025.

Eregzen, G. “Khünnüd burkhny shashin delgerch baisan uu?” [Was Buddhism Spread in the Xiongnu?]. In “*Buddyn shashin ba arkheologi*” [Buddhism and Archaeology] conference proceedings. Ulaanbaatar, 2022.

Xuchi. Stone buddha on the steppe and the shaping of imperial authority: Transmission of buddhism to the Turkic khaganate during the 6th to 8th century. “*Ancient cultures of Mongolia, Baikal, Southern Siberia and Northern China*” the 13th international conference. Ulaanbaatar, 2025.

Peter Stewart. Gandharan art and the classical world a short introduction. Archaeopress. 2024. <https://doi.org/10.2307/jj.15135910>

Kurt A. Behrendt. The art of Gandhara in the Metropolitan museum of art. Yale University press, 2007.

Kurt A. Behrendt. Gandhāran imagery as remembered by Buddhist communities across Asia. The Rediscovery and Reception of Gandhāran Art (Archaeopress 2022): 107–123 <https://doi.org/10.32028/9781803272337-5>

Shuangqiao Meng and Peining Li. From the Malay Peninsula to the Shandong Peninsula: The Transmission of Buddha Statues with Tight-Fitting Robe in the Sixth Century. *Religions* 2023, 14, 84. <https://doi.org/10.3390/rel14010084>

《Bei shi》 Juan jiushiba 《Ruanruan》 Zhonghua shuju, 2000 nian, 2157 ye.

《Wei shu》 Juan yibaisan 《Ruanruan》 Zhonghua shuju, 2000 nian, 1549 ye.

(Liang) Shi Huijiao: 《Gao seng chuan》 Juan ba 《Fa ai chuan》, Zhonghua shuju, 1992 nian, di 312 ye.

He Zhiguo 《Shi lun zao qi fo tuo、pu sa xiang ming shi bu fu de xian xiang——yi zao qi jin tong fo xiang wei zhong xin》 Wen wu yan jiu 2021 nian di yi qi, 130-138 ye.

Ren Jiyu zhu bian: 《Zhong guo fo jiao shi》 Di yi juan, Zhong guo she hui ke xue chu ban she, 1981: 91.

Zhong hua shi ji tan yi shu guan、Qing zhou shi bo wu guan 《Qing zhou bei chao fo jiao zao xiang》 Bei jing chu ban she 2002 nian.



Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>